



**ГОВЬСУМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 18 өдөр

Дугаар №65

Шивээговь сум

Газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Газрын тухайн хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 30 дугаар зүйлийн 30.1, 38 дугаар зүйлийн 38.4, Газар зохион байгуулалт геодези, зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 5.4.2.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монголмууд овогт Батчулуун Цэрэндорж /ОЖ67100618/ нь Шивээговь сумын 1-р баг, 10 дугаар байрны зүүн талд “Автограф”-ийн зориулалттай 21м 2 газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул иргэн Монгол овогт Төмөрийн Эрдэнэхүү /УС77051300/ Шивээговь сумын 1-р баг, 10 дугаар байрны зүүн талд байрлах 21м 2 газрыг “Автограф”-ийн зориулалтаар эзэмших эрхийг анх авсан этгээдийн үлдсэн хугацаагаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Монгол улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хуулийг дагаж мөрдөхийг газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн /Т.Эрдэнэхүү/-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийг шилжүүлэн авч буй иргэн Т.Эрдэнэхүүтэй газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал /Т.Өлзийбуд/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2019 оны А/95 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА

П.ГАНЧИМЭГ



42723 222